

ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕД НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

IMPROVING LEGAL REGULATIONS OF MAINTAINING PUBLIC-ORDER AND PUBLIC SAFETY DURING PUBLIC CULTURAL AND ENTERTAINMENT EVENTS



Ю.БАДАМХАНД

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хурандаа

BADAMKHAND YU.

Ph. D., Police colonel, Head of Police Law Department of the Police institute, Law Enforcement University

Товч агуулга: Энэхүү нийтлэлд нийтийг хамарсан соён гэгээрүүлэх, цэнгээнт, зар сурталчилгааны болон бусад үзвэрийн арга хэмжээ, тэдгээрийг явуулах үед нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судлан авч үзсэн.

Abstract: The article describes some problems of legal regulations for organizing entertainment, promotional and other types of events among the public and provides some recommendations to improve legal regulations of this industry.

Түлхүүр үгс: Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдал, олон нийтийг хамарсан арга хэмжээ, соёл урлагийн арга хэмжээ, эрх зүйн зохицуулалт.

Key words: Maintaining public-order, public safety, public events, improving legal regulations.

Олон нийтийг хамарсан соёл урлаг, спортын цэнгээнт арга хэмжээний үеэр нийтийн хэв журам зөрчсөн аливаа үйлдэл, танхайрал, хүчирхийлэл, хэт даврах ажиллагаа, террорист халдлага үйлдэхээр заналхийлэх зэрэг нь нийгмийн асар их бухимдлыг бий болгодог. Тиймээс хууль бус үйлдлийг гарахаас өмнө болон дараа нь урьдчилан сэргийлэх, таслан зогсоох захиргааны болон эрх зүйн механизмыг бий болгох бодит хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Эрх зүйн зохицуулалт нь соёл урлаг, үзвэрийн арга хэмжээг хариуцан явуулах тухайн байгууллагын төдийгүй түүний ойр орчмын газарт байрлах нийтийн, үйлчилгээний газруудын эрх зүйн байдлыг тодорхой болгоно.

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай¹ хуулийн "Нийтийн хэв журам хамгаалах" гэсэн 10 дугаар зүйлийн

10.1.-д "Цагдаагийн байгууллага нь хуулиар харьяалуулсан хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулж нийтийн хэв журмыг хамгаална", "Олон нийтийн аюулгүй байдлыг хангах" гэсэн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д "дипломат төлөөлөгчийн газар, ..., шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, ..."; 11.1.6-д "нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалт хийх"; Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах" (код 500) журмаар² цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын төрөл, тэдгээр ажиллагааны арга хэлбэр, дэг горимыг тогтоохтой холбогдон үүссэн харилцааг зохицуулах

¹ Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл. 2013. № 29.

² ЦЕГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/44 тоот тушаалаар батлагдсан "Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах" (код 500) журам.



ба шаардлагатай тохиолдолд³ иргэдэд гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөгөө өгөх; гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, жагсаал цуглаан болох газар орчинд хэв журмын эргүүл ажиллуулах зэрэг асуудлыг тусгасан. “Жагсаал, цуглааныг албадан тараах” (код 503) журмын 503.5-ын г-д “тухайн нөхцөл байдалд бодит үнэлэлт, дүгнэлт хийж, үүсч болох нөхцөл, гарч болох эрсдэлийг тооцно” гэж заасан боловч эрсдэлийг хэрхэн тооцох, ямар арга хэмжээ авах талаар нарийвчлан тусаагүй байна.

Монгол Улсын Жагсаал, цуглаан хийх тухай хуулийн (1994) 13 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллага нь хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалж, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй⁴, 11 дүгээр зүйлд зааснаар жагсаал, цуглаан зохион байгуулагчид жагсаал, цуглаан хийх газарт нийтийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй гэж заасан нь жагсаал, цуглааны үед нийтийн хэв журам сахиулах, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулж байна.

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд⁵ зааснаар аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд нь байгууллагынхаа дотоодод болон үйл

³ Мөн журам. 500.10.1 шаардлагатай тохиолдолд иргэдэд гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөгөө өгөх; 500.12. Эрүүгийн цагдаагийн албаны үүрэг. 500.12.2. Тодорхой байршлын болон байгалийн гамшиг, ослын хамгаалалтын үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах арга хэмжээ авна; 502.5.1 жагсаал цуглаан болох газар орчинд хэв журмын эргүүл ажиллуулах;

⁴ Монгол Улсын Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль. 13.2. Жагсаал, цуглааны явцад хэв журам хамгаалах нэмэгдэл арга хэмжээ шаардлагатай бол зохион байгуулагч нь энэ тухай хүсэлтээ цагдаагийн байгууллагад гаргана. //http://legalinfo.mn/law/details/252?lawid=252

⁵ Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль (1997). 9 дүгээр зүйлийн 9.1.1. байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах; 9.1.2. ажилтнууддаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах нийтлэг үүрэг хүлээнэ. Төрийн мэдээлэл. 1998. №1.

ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтлэг үүрэг хүлээдэг.

Дээрх хууль тогтоомжид зааснаар цагдаагийн байгууллага нь гүйцэтгэх засаглалын болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн хурал, жагсаал, цуглаан, бусад нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагчидтай хамтран иргэдийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахиулах; хууль тогтоомжийн хүрээнд соёл урлаг, спортын болон бусад нийтийг хамарсан цэнгээнт арга хэмжээг зохион байгуулагч нарт иргэдийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахиулахад нь туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх газар, хэлтэс, албадуудыг цагдаагийн байгууллагад шинэчлэн зохион байгуулсан.

Жагсаал, цуглаанаас ялгаатай нь соёл урлаг, спортын болон бусад нийтийг хамарсан цэнгээнт арга хэмжээ зохион байгуулагчдад цагдаагийн байгууллагаас зөвхөн дэмжлэг үзүүлж байна, өөрөөр хэлбэл тухайн нөхцөлд дэг журам, аюулгүй байдалд хяналт тавих үндсэн үүрэг цагдаагийн байгууллагад бус тухайн арга хэмжээг зохион байгуулагчдад оногдож байна.

Олон нийтийг хамарсан соёл урлаг, спортын, цэнгээнт арга хэмжээний үеэр иргэдийн аюулгүй байдлыг хангах, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэх нь зохион байгуулагчдын үүрэг юм. Гэвч эдгээр арга хэмжээ зохион байгуулагчдаас хуульд заасны дагуу уг арга хэмжээний явцад иргэдийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах арга хэмжээ авах өөрсдийн үүргээ ухамсарлан биелүүлэх ажиллагаа дутмаг, энэ чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй байна. Тухайлбал, арга хэмжээний үеэр нийтийн болон бусдын өмч хөрөнгөд хохирол учруулахгүй байх талаар сэрэмжлүүлэх, орчин тойрондоо болон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл (халуун, хүйтэн зэвсэг,

хорт болон тэсэрч дэлбэрэх бодис зэрэг), амьтан авч явж болохгүйг оролцогчдод урьдчилан анхааруулах; согтууруулах ундаа, мансууруулах буюу хорт бодис хэрэглэсэн болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийг оролцуулахгүй байх арга хэмжээ авах, согтууруулах ундаа хэрэглүүлэхгүй байх зэрэг болно.

Гадаадын зарим улсад спорт, үзвэр үйлчилгээ, зугаа цэнгэлийн арга хэмжээ явагдаж байгаа газрын гадна цагдаа нь бэлэн байдалд байж, зөвхөн уг арга хэмжээг зохион байгуулагчдад тусламж хэрэгцээтэй болсон үед хүрч очиж тусалцаа үзүүлэхээр цагдаагийн байгууллагын эрх үүргийг тодорхой заасан хэм хэмжээнүүд үйлчилдэг байна. Дэг журмыг сахиулахад татагдан ажиллаж буй цагдаа нарын илүү цагийн ажлын хөлсийг уг арга хэмжээг зохион байгуулж тодорхой хэмжээний ашиг олж байгаа гэдэг утгаараа зохион байгуулагчид нь хариуцан, тусгай дансанд хийдэг аж. Энэ туршлага нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, иргэдийг хууль дүрмийг дагаж мөрдүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг байна. Тухайлбал:

ОХУ-д “О собраниях, митингах, демонстрациях, шествиях и пикетированиях⁶” гэж хурал, цуглаан, жагсаал, дуугүй эсэргүүцэл, тайван (явган) жагсаал зэргийг зохицуулах (2004) 3 бүлэг, 19 зүйлтэй хуультай. Уг хуульд нийтийг хамарсан дээрх арга хэмжээг зохион байгуулах, явуулах, зохион байгуулагч, оролцогчдын эрх үүрэг, гомдол хүсэлт гаргах, уг арга хэмжээг зохион байгуулах газар, орон нутгийн байгууллагуудын хүлээх үүрэг, арга хэмжээ явагдах газар, явуулахыг татгалзах, зогсоох үндэслэл зэргийг нарийвчлан тусгасан ба судлан буй нийтийг хамарсан урлаг, цэнгээнт үзвэрийн арга хэмжээний талаар зохицуулалт байхгүй байна. Харин уг хуулинд нийтийг хамарсан арга хэмжээний төрөл тус бүрийг нарийвчлан тодорхойлсон байдаг.

⁶ Федеральный закон от 19 июня 2004 г. N 54-ФЗ «О собраниях, митингах, демонстрациях, шествиях и пикетированиях».

<http://base.garant.ru/12135831/#ixzz3y8BdSVfEi/>

Тухайлбал, нийтийн арга хэмжээ (публичное мероприятие) - нээлттэй, тайван замаар, хэн бүхэнд хүртээмжтэй байдлаар ОХУ-ын иргэн, улс төрийн нам, олон нийтийн нэгдэл, шашны байгууллагаас явуулж буй хурал, цуглаан, жагсаал, дуугүй эсэргүүцэл, явган жагсаал эсхүл эдгээртэй төстэй бусад хэлбэрийн арга хэмжээнүүд ба тээврийн хэрэгсэл ашиглан явагдаж болно. Шествие – ямар нэгэн асуудалд анхаарал хандуулахын тулд урьдчилан тодорхойлсон маршрутаар олон иргэд явж өнгөрөх; пикетирование – олон нийтийн үзэл бодлоо илэрхийлэх хэлбэр ба явуулж байгаа газартаа хөдөлгөөнгүй байдлаар, ямар нэгэн чанга яригч хэрэгсэл ашиглахгүйгээр нэг ба хэдэн оролцогч плакат зураг, сурталчилгааны үзүүлэн ашиглан явуулна.

Спортын арга хэмжээний тухайд 1983 онд батлагдсан⁷ «О введении в действие «положения о мерах по обеспечению общественного порядка и безопасности, а также эвакуации и оповещения участников и зрителей при проведении массовых спортивных мероприятий» (монг. Олон нийтийг хамарсан спортын арга хэмжээний үеэр нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, түүнд оролцогч, үзэгчдийг нүүлгэн шилжүүлэх, мэдэгдэл өгөх журам) одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа ба стандартын бус, задгай газар, уул, ой, авто зам, гол усанд зохион байгуулагдах спортын арга хэмжээнд тусгай шаардлагууд тавигддаг байна. Харин томоохон шоу, концерт, цэнгээнт арга хэмжээ зохион байгуулагчдын санаачилгаар “Соёл-үзвэрийн арга хэмжээг зохион байгуулах тухай” (О проведении культурно-зрелищных мероприятий) хуулийн төсөл боловсруулагдан хэлэлцэгдэж байгаа юм байна.

Турк улсад 2015 оны 07 дугаар сарын 01-нээс “Об организации и проведении собраний, митингов, демонстраций и

⁷ Приказ Спорткомитета СССР от 17.10.83 N 786 «О введении в действие «положения о мерах по обеспечению общественного порядка и безопасности, а также эвакуации и оповещения участников и зрителей при проведении массовых спортивных мероприятий».



других массовых мероприятий⁸ (монг. Хурал, цуглаан, сүрт жагсаал, бусад нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, явуулах тухай) хуулийг батлан хэрэгжүүлж байна. Энэ хууль 4 бүлэгтэй, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах, явуулах, зохион байгуулагч, оролцогчдын эрх үүрэг, гомдол хүсэлт гаргах, уг арга хэмжээг зохион байгуулах газар, орон нутгийн байгууллагуудын хүлээх үүрэг, арга хэмжээ явагдах газар, явуулахыг татгалзах, зогсоох үндэслэл зэргийг нарийвчлан тусгасан ба судлан буй нийтийг хамарсан урлаг, спорт, цэнгээнт үзвэрийн арга хэмжээний талаар нарийвчлан зохицуулагдаагүй байна.

Беларусь улсад 1997 оноос “О массовых мероприятиях” (монг. Олон нийтийн арга хэмжээний тухай) хууль⁹ хэрэгжиж байгаа, 2 удаа нэмэлт өөрчлөлт орсон. Уг хуулинд нийтийн арга хэмжээнд хурал, цуглаан, дуугүй эсэргүүцэл, тайван (явган) жагсаал зэрэг арга хэмжээг; бусад нийтийг хамарсан арга хэмжээнд зориулалтын бус газарт (задгай газар эсхүл байр саванд) явагдаж буй спорт, соёл-үзвэрийн, бусад цэнгээнт арга хэмжээг оруулан тус бүрийн тодорхойлолтыг өгсөн байдаг.

АНУ-д жагсаал, олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг муж, орон нутаг өөрийн эрх хэмжээний хүрээнд зохицуулдаг байна. Жагсаал цуглаан хийх тусгай зөвшөөрөл авсан байх (15-40 хоногийн өмнө) шаардлагатай ба орон нутгийн цагдаагийн газар, эсхүл үндэсний паркуудын алба (хэрэв түүний эрх хэмжээнд багтаж байвал) зэрэг газрын албан ёсны цахим хуудаст байршуулсан өргөдлийн загварын дагуу хүсэлт гаргана. Гал, зам тээвэр, цагдаагийн байгууллагын харилцан зөвшилцлийн үндсэн дээр орон нутгийн захиргаанаас тусгай зөвшөөрлийн

гэрчилгээ олгодог. АНУ-ын зарим муж, хотод “чимээ аниргүй байх бүс”, засгийн газрын барилга байгууламж, захиргааны байрын ойр орчим явуулахыг хориглодог, 5 км-ээс хол явахгүй байхыг шаарддаг, төлбөр авдаг. Хэрэв зохих зөвшөөрөлгүй, тогтоосон журам зөрчин явуулбал орон нутгийн захиргаанаас тусгай хэрэгсэл хэрэглэх, зарим этгээдийг нь баривчлах зэрэг таслан зогсоох арга хэмжээ авах эрхтэй. Зарим тохиолдолд зэвсэгт хүчнийг оролцуулахаар тусгагдсан.

Герман улсын хувьд мөн адил «О собраниях и шествиях» (монг. Хурал, цуглааны тухай) хуультай, 1953 оноос хэрэгжиж буй, 1978 онд шинэчлэн найруулсан. Онцгой тохиолдолд цагдаагийн байгууллага галт зэвсэг хэрэглэх эрхтэй, “браво” гэж олон дахин чанга хамтаар хашгирах байдлаар уриалан дуудах, нүүрээ будаж, маскдахыг хориглодог.

Англи улсад 1986 он хүртэл нийтийг хамарсан арга хэмжээ (жагсаал, цуглаан, бусад)-ний үед нийтийн дэг журам сахиулах асуудлыг зохицуулах гол хууль нь 1936 оны “Закон об охране общественного порядка” (англ. Public Order Act, монг. Нийгмийн дэг журам сахиулах тухай) байсан ба 1986 онд шинэчлэн найруулж, гарч болох эрх зүйн зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлага, зөвшөөрлийн асуудлыг тодотгон тусгажээ. Уг хуулинд “нийтийг хамарсан эмх замбараагүй байдал”, “хүч хэрэглэсэн эмх замбараагүй байдал”, “заналхийлсэн төрх байдал” гэсэн ойлголтуудыг тодорхойлсон. Дотоод хэргийн байгууллагын бүтцэд Үндэсний хөл бөмбөгийн хэлтэс (хуучнаар Үндэсний хөлбөмбөгийн тагнуулын алба) ажилладаг, спортын арга хэмжээ зөрчигсдийн талаар мэдээлэл цуглуулж, тэднийг спортын арга хэмжээ явагдах байр газарт нэвтрүүлэхгүй байхад хяналт тавьж, фен-клуб, спортын клубүүдэд урьдчилан сэргийлэх ажил явуулдаг байна. Цагдаагийн байгууллага зохион байгуулагчдын зүгээс хүсэлт тавьсан тохиолдолд л аюулгүй байдлыг хангахаар оролцдог, тухайн зохион

⁸ Закон Туркменистана “Об организации и проведении собраний, митингов, демонстраций и других массовых мероприятий” (Ведомости Меджлиса Туркменистана, 2015 г., № 1, “Нейтральный Туркменистан”, № 61 (27699) от 11 марта 2015 г.)

⁹ Закон республики Беларусь. О массовых мероприятиях в республике Беларусь. 30 декабря 1997 г. N 114-З.



байгуулагч нараас илүү цагийн хөлс төлдөг. Мөн билет дамлан худалдахыг хориглодог, энэ нь тухайн газарт эрхээ хасуулсан этгээдүүд нэвтрэхээс урьдчилан сэргийлэхэд тустай байна.

Япон улсад тухайн орон нутгийн байгууллагаас батлан гаргасан журмаар зохицуулдаг байна.

Зохих зөвшөөрөлгүй жагсаал, цуглаан хийсэн тохиолдолд авах торгуулийн хэмжээ улс орнуудад харилцан адилгүй байна. Тухайлбал:

- АНУ-д 300 ам. доллараас 1 жилийн хорих ял,

- Англид 400 фунт стерлингийн торгуулиас 5 жилийн хорих, 2000 фунт стерлингийн торгох ял,

- ОХУ-д зохион байгуулагч нарыг 1000-2500 рубль, оролцогч 500-1000 рубль, 15 хоног баривчлах ял,

- Германд 1 жил хүртэл хорих, 15000 еврогоор торгох,

- Францад 1 жил хүртэл хорих эсхүл түүнтэй дүйцэх мөнгөн торгууль, 3 жил хүртэл хорих ял,

- Италид 1-12 сар хорих, их хэмжээний мөнгөн торгууль,

- Шведэд зохион байгуулагчид 4 хүртэл, оролцогчид 2 хүртэл жил хорих ял,

- Японд 50000 иен торгох, эсхүл 1 жил хүртэл албадан ажил хийлгэх, хорих ял тус тус ногдуулдаг байна.

Монгол Улсын Жагсаал, цуглаан зохион байгуулах тухай хуулийг баримтлан олон нийтийг хамарсан бусад арга хэмжээг шууд зохицуулах боломжгүй, учир нь тэд бүгд¹⁰ өөр өөрийн гэсэн онцлогтой. Соёл урлаг, спортын, цэнгээнт арга хэмжээ нь ихэвчлэн урлаг соёлын үр шимийг иргэдэд хүргэх, соён гэгээрүүлэхтэй холбоотой, нөгөө талаар тусгай оролцогч үзэгч болон тэдгээрийн хоорондын харилцаа байдаг тул бие даасан эрх зүйн зохицуулалтын объект болох ёстой. Спортын ба соёлын арга хэмжээ явагдах газарт аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах асуудал хоорондоо ихээхэн ялгаатай. Тухайн арга хэмжээг зааланд, эсхүл задгай

¹⁰ Нийтийг хамарсан арга хэмжээнүүд нь өөр өөр нэршилтэй байна: соёл-олон нийтийн, театрчилсан-үзвэрийн, хошин шогийн, шоу арга хэмжээ, соёл-соён гэгээрүүлэх, нийтийг хамарсан цэнгээнт г.м.

талбай, цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулах нь зарчмын хувьд ялгаагүй ч эрх зүйн зохицуулалт талаас нь өөр хандлагаар хандахыг шаардана.

Олон нийтийн зүгээс интернет ашиглан үг хэл, үзэл бодлоо илэрхийлэх, улмаар урьдчилан тохиролцож, тогтоосон цагт, тогтсон газарт цуглаан, дуугүй суулт, флашмоб¹¹ бүжгээр эсэргүүцэл илэрхийлэхийг үгүйсгэхгүй, энэ тохиолдолд хэрхэн авч үзэх, аюулгүй байдлын асуудлыг хэрхэн зохицуулах нь ойлгомжгүй байна. Мөн зориулалтын бус газарт өөр арга хэмжээ зохион байгуулах (циркэд шоу цэнгээн, бөхийн өргөөнд концерт зохион байгуулах зэрэг) тохиолдолд хэв журам, аюулгүй байдлын асуудлыг ч нарийвчлан зохицуулах хэрэгтэй гэж үзэж байна.

Манай улсад томоохон урлаг соёл, спорт, үзвэрийн арга хэмжээг зохион байгуулах явцад нэг талаас - зохион байгуулагч ба тухайн арга хэмжээ явагдаж буй газрын эзэд хоорондын, нөгөө талаас нийгмийн дэг журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах субъектүүд, түүнчлэн үзэгчид ба оролцогч нарын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулах хууль тогтоомж үгүйлэгдэж байна. Ийм зохицуулалт нь нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг бүрэн хэмжээнд хангах, гарч болзошгүй гэмт хэрэг, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авахад тустай юм.

САНАЛ

1. Монгол Улсын "Жагсаал, цуглаан зохион байгуулах тухай хууль"-д хурал, цуглаан, жагсаал, дуугүй эсэргүүцэл, тайван жагсаал, явган жагсаал зэрэг ойлголтуудын зааг ялгааг нарийвчлан тусгасан нэмэлт өөрчлөлт оруулах

2. Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын (Зөрчлийн) тухай хуулиудад соёл, урлаг, спорт, цэнгээнт, сурталчилгааны зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед зохион байгуулагчид болон өмчлөгч эздийн зүгээс урьдчилан

¹¹ олноор нийлж бүжиглэх.

сэргийлэх, аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ аваагүй, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлагын механизмыг тусгаж өгсөн нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах. Гэхдээ хүлээлгэх гэж буй хариуцлага нь гарч болзошгүй, эсхүл бий болсон үр дагавраас нь хамааран ялгавартай байх нь зүйтэй болов уу.

3. “Олон нийтийг хамарсан соёл урлаг, спорт, үзвэрийн арга хэмжээг явуулах журам”-ын тухай хуулийг батлан гаргах, эсхүл энэ чиглэлийн үйл ажиллагааг хуульчлан зохицуулах. Үүнд:

- “олон нийтийг хамарсан соёл, урлаг, үзвэрийн арга хэмжээ” болон “соёл урлаг олон нийтийн үзвэрийн арга хэмжээ зохион байгуулах газар” гэсэн ойлголтуудыг тодорхойлох;

- стандартын бус, задгай газар, уул, ой, авто зам, гол усанд зохион байгуулагдах спортын арга хэмжээний төрлүүд, тэдгээрт тавигдах тусгай шаардлагыг тусгах;

- нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагч, нийтийн дэг журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах субъектүүд, үзэгч,

оролцогч нарын эрх, үүргийг тодорхой болгох;

- зөрчил дутагдал илэрсэн үед зохион байгуулагчдын зүгээс шаардлагатай арга хэмжээг авах, холбогдох байгууллагад (даруй) мэдээлэхийг үүрэг болгох;

- эрх бүхий байгууллагаас гомдол хүсэлтийг хүлээн авч хэлэлцэх, уг арга хэмжээг явуулахыг зөвшөөрөх, татгалзах эсхүл зогсоох шийдвэр гаргах үндэслэлийг тодорхойлох;

- уг соёл, урлаг, спорт, үзвэрийн арга хэмжээ нь “олон нийтийг хамарсан” арга хэмжээ мөн эсэхийг тодорхойлохын тулд оролцогчдын тооны доод (дээд) хязгаарыг тогтоох;

- зөвхөн “тодорхой хүрээний” хүмүүсийн дунд зохион байгуулах арга хэмжээ, түүнд тавигдах тусгай шаардлагыг тусгах;

- эдгээр арга хэмжээний үеэр нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллагын оролцоог хуульчлан журамлах.



Хууль сахиулахуй

Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, доктор, цагдаагийн хурандаа Б.Одбаатар